

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын
2022 оны дугаар сарын-ны өдрийн
.... дугаар албан бичгийн хавсралт

ШШГБ-ЫН 2022 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ҮР ДҮНД СУУРИЛСАН ЯВЦЫН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН ЗӨВЛӨМЖ

2022 оны 07 дугаар сарын 08

Улаанбаатар хот

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг баримтлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2022 оны үйл ажиллагаанд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналт шинжилгээний хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газраас Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, байгууллагын ил тод байдлыг илтгэх талаар болон 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг хэрэгжүүлсэн байдлын үр дүнг үнэллээ.

Бодлогын баримт бичиг, эрх зүйн актын хэрэгжилт, үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг үнэлж дүгнэхдээ Захиргааны удирдлагын газраас нэгтгэн гаргасан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт болон бусад тайлан, мэдээнд тулгуурласан болно.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын явцад зарим тайлан мэдээллийн хэрэгжилтийн байдалд нэмэлт тодруулга авах, асуудал хариуцсан нэгжээс тайлбар авах зэргээр мэдээллийн чанарыг сайжруулах, бататгах ажлыг гүйцэтгэв.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын үйл ажиллагааны үнэлгээний дүн:

Бодлогын баримт бичиг, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдал гэсэн үндсэн 3 үзүүлэлтийн хүрээнд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааг нэгтгэн дүгнэвэл үнэлгээ 53.08 хувьтай 2.65 оноотой үнэлэгдлээ. Үнэлгээний дүнг хүснэгтээр үзүүлвэл:

	Үзүүлэлт	Үнэлгээ	Оноо
1.	Бодлогын баримт бичгийн үнэлгээ	51.23%	2.56
2.	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	53%	2.65
3.	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	55.02%	2.75
	Ерөнхий үнэлгээ	53.1%	2.65

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 2022 оны үйл ажиллагаанд эхний хагас жилийн байдлаар үр дүнд суурилсан явцын үнэлгээ 53.1 хувь 2.6 оноотой дүгнэгдэж байгаа нь Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам"-ын 6.2.3-т зааснаар шилжүүлэн тооцоход "Эрчимжүүлэх шаардлагатай" буюу зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, зорилгод чиглэсэн арга хэмжээ авах шаардлагатай гэж дүгнэгдэж байна. Иймд үйл ажиллагааны гүйцэтгэл, үр дүнг нэмэгдүүлэх талаар дараах зөвлөмжийг өгч байна.

Нийтлэг хэрэгжүүлэх зөвлөмж:

1. ХЗДХЯ-наас болон ШШГЕГ-ын Хяналт шалгалт, аюулгүй байдлын газраас тус байгууллагын тухайн жилийн үр дүнг үнэлсэн үнэлгээний мөрөөр өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах, хэвшил болгох;

2. ШШГЕГ-ын харьяа алба, газар, зохион байгуулалтын нэгжүүдийн хоорондын ажлын уялдаа, хамтын ажиллагаа хангалтгүй, зарим албаны тайлан хангалтгүйгээс үр дүнг тооцох, хэмжээс хийх боломжгүй байдал үүсгэж байгаа нь хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээ, тайланг ХЗДХЯ-нд тайлагнахад хоцрох эрсдэлтэй байна. Иймд Захиргааны удирдлагын газар шаардлага хангахгүй тайланг буцаах, боловсруулалт хийж ирүүлэх;

3. ШШГЕГ-ын харьяа алба газрууд Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан "Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам", 217 дугаар тогтоолоор баталсан "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам", 218 дугаар тогтоолоор баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж, батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын дагуу байгууллагын бодлого төлөвлөлтийн нэгдмэл байдал, уялдаа, холбоог хангаж төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулан хэрэгжилтийг ханган, тайланг чанартай ирүүлэх, нотлох баримтыг тогтмол хавсаргах;

4. Бодлогын баримт бичиг болон түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулалтад ХШҮ-ний нэгжээс болон харьяа албадын төлөвлөлт хариуцсан албан хаагчдын оролцоог хангах;

5. ШШГЕГ-ын харьяа алба, газрууд нь бодлого төлөвлөлтийн баримт бичигт үндэслэн уялдаа холбоог хангаж ажлын дэд төлөвлөгөө гарган, хэрэгжилтэд хяналт тавих;

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас хэрэгжүүлэх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг тухайн жилд шинэчлэн тогтоосныг хяналтад авч, шийдвэрийг хэрэгжүүлэх талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

7. Төсөв хөрөнгө шаардсан, тооцоо судалгаа гаргаж ХЗДХЯ-нд танилцуулсан арга хэмжээ цөөнгүй байна. Энэ талаар бодлогын түвшинд авч үзэх нь зүйтэй бөгөөд улсын төсвийн 2023 оны хөрөнгө оруулалтад ХЗДХЯ-наас дэмжлэг авах талаар санаачлагатай ажиллах;

8. Зорилт арга хэмжээ тус бүрийн хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийн биелэлтийг тухайн жилд хүрсэн түвшин, зарцуулсан хөрөнгийн хэмжээтэй нь тайлагнаж, баримтыг хавсаргах;

9. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг 2022 оноос эхлэн Төрийн мэдээллийн системд байршуулах ажлыг нэвтрүүлээд байна. Үнэлгээний мэдээлэл бүхий ажлын баримт, материалыг баримтжуулж хавсарган оруулснаар баталгаажиж, Хууль зүй, дотоод хэргийн яаманд нэгтгэгдэн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын хяналтад авагдаж байхаар

зохицуулагдаж байна. Иймд холбогдох алба хаагч, мэргэжилтнүүд ажлын нотломжийг PDF-ээр хавсарган ирүүлж байх, цаашид тогтмолжуулах;

10. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа алба, газрууд нь тухайн жилийн төлөвлөлтийн хүрээнд гүйцэтгэх тайлан, түүнийг нотлох ажлын баримт, материалыг гаргахдаа албаны нууцад хамаарахгүй бусад асуудлын талаарх мэдээллийн агуулга, чанар, стандарт, багтаамж, хэлбэр, загварыг оны эхнээс тодорхой болгох талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах; гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх нь зүйтэй байгааг илтгэн танилцуулъя.

-----ooOoo-----